

***Pax Mongolica*-гийн талаар эрэгцүүлэн бодохуй**

Удо Б.Баркманн (МУИС)

Сүүлийн жилүүдэд монголын түүхчид өнөөгийн даяаршлалын явцын нөлөөгөөр *Pax Mongolica* гэсэн нэр томъёог илүүтэйгээр хэрэглэх болжээ.¹ *Pax* гэдэг бол энх тайвныг бэлэгдэх ромын бурхны нэр агаад бидэнд *Eirene* гэдэг грек нэрээрээ танил болсон юм. Иймд *Pax Mongolica*-г "монголын энх" гэсэн утгаар хэрэглэж буй бөгөөд үүнийг *Pax Romana*, өнөө үед бол *Pax Americana*-тай хэлний хувьд төстэй гэж ойлгож болох юм.

Pax Mongolica гэсэн нэр томъёо нь Монголын их эзэнт гүрний мандан бадарч, задран бутарч асан түүхийн тэр нэгэн үетэй холбоотой. Энэ нэр томъёо нь Монголын их эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтах янз бүрийн улсууд элдэв саад тотгоргүйгээр Европтой худалдаа хийх нөхцлийг түүхэнд анх удаа бүрдүүлж улмаар Европ болон Төв, зүүн Азийн түүхийг хооронд нь холбож өгсөн тэрхүү системийг томъёолж байгаа юм. Татааруудын тухай дурдсан байдаг 13-15 зууны латин хэлт эх сурвалжуудад *Pax Mongolica* гэсэн нэр томъёо тэмдэглэгдээгүйг бид Шмийдэрийн² хийсэн судалгааны ажлаас мэдэх билээ. Энэ нэр томъёог сүүлийн үеэс л хэрэглэх болжээ. Чухамдаа бид монголч болон иран судлаач (Д.Морган), хятадач (Х.Франке) нарын Монголын их эзэнт гүрний үеийн аж ахуйн харилцаа ялангуяа худалдаа наймаа, арилжаа солилцооны тухай өгүүлсэн түүхийн судалгааны бүтээлүүдээс энэхүү *Pax Mongolica* гэсэн үгийг олох болно. Гэвч өнөөг хүртэл энэ нэр томъёог их бага ямар нэгэн хэмжээгээр гипотезийн маягаар хэрэглэж буйг хязгаарлах хэрэгтэй байна. Энэ асуудлын тухайд дорвитойхон судалгааны ажил урьдын адил мөн л үгүйлэгдсээр байна. Иймд миний дор өгүүлсэн зүйл зөвхөн санаа оноо өгөх зорилготой болохыг та бүгд болгооно уу.

Чингис хаан Монголын их эзэнт гүрнийг байгуулсан явдал *Pax Mongolica*-г тогтоох нөхцлийг бүрдүүлэх урьдач гол нөхцөл, орчин нь болсон юм. Гэвч энэхүү зүйрлэх аргагүй байлдан дагууллыг хийхэд

¹ Д. Баярхүү, *Евроазийн Геополитик - одоо, Олон Улсын Харилцаа, ирээдүй*, Улаанбаатар 2002.

² F. Schmieder, *Europa und die Fremden im Urteil des Abendlandes. Die Mongolen im Urteil des Abendlandes vom 13. bis in das 15. Jahrhundert*, Sigmaringen 1994.

Чингисийг хөтлөн аваачсан зүйл нь ингэхэд юу байв гэсэн асуултад хариулахад тийм ч хялбар бус юм. Дээд тэнгэрээс заяат төрсөн гэдэгтээ Чингис бүрэн итгэж байснаас үүнийг үүдэлтэй гэж юуны өмнө бид үзэж болох талтай. Үүний нотолгоог бид *Монголчуудын Нууц Товчооноос* олж болох бөгөөд түүнд тэмдэглэн үлдээснээр Чингис "Би бээр эрхт тэнгэрээс заяат бөлгөө, газар эхийн элч билээ ..." хэмээн олонтаа өгүүлсэн байдаг.³ Дээд тэнгэрээс заяат төрсөн гэж өөрийгөө үзэх хүн нь ганц Чингис биш байлаа. Талын бусад эрх баригчид ч өөрсдийгөө тэнгэр язгуурт гэдэгт итгэж байв. Найманы Даян хаан Чингисийг үл тоон "... газарт хоёр хаан байж яахин болох билээ" гэж хэлсэн байдаг.⁴

Нүүдэлчдийн хааны хүч чадлын гол тулгуур нь нөхөд байдаг билээ. Нүүдэлчдийн хаан дайнд аз хийморьтой байж, өөрт хүчээ өгч буй нөхөд сэлтээ олз омгоор шагнаж дөнгөхүйц болсон чухам тэр үед нь л түүнийг олон нөхөд тойрон хүрээлэх болсон юм. Дайны олз бол зөвхөн ганц эрх баригчийн өмчид тооцогдох бөгөөд үүнийг байгуулсан гавъяаных нь дагуу нөхөддөө хувааж өгдөг байв. Нөхдийн тоо өсөхийн хамт олз омог олохын тулд аян дайныг ахин дахин хийх шаардлага нэмэгдэж байлаа. Юуны өмнө олз омог нь материаллаг, биет зүйлээс бүрдэж байлаа. Хожим Чингис ач гавъяатай нөхдийг өндөр албан тушаалд томилохын зэрэгцээ үзэсгэлэн гоо эмс хатад, эзлэгдсэн орны ардыг харьяат болгон шагнах болсон. Дээрэм тонуул, эзлэн түрэмгийлэлд тулгуурласан аж ахуй хэмээх нэр томъёогоор зарим түүхчдийн тодорхойлсон байнга олз олох зарчим тасралтгүй явагдаж байх шаардлагатай байв. 1206 онд "Эсгий туургатан нүүдэлчин ардыг нэгтгэсний" дараа Чингис энэ зарчмыг халж чадах байсан болов уу? Бараг л үгүй байх. Энэ нь талын их гүрнийг төгсгөл болгох байсан биз ээ. Нөхөд сэлт нь түүнээс нүүр буруулан одож, хоорондоо дайтан, улмаар түүний чадан ядан нэгтгэсэн монгол угсаатан бутарч орших байсан биз ээ. Энэ тухайд Чингис хаан Хойд Хятадын Жин улсад аян дайныг хийхээр шийдсэн нь зөвхөн Жингийн хаанаас эртний өшөөг авах гэсэн хэрэг огт бус харин Жин улсын хэмжээлшгүй их эд баялгыг олзлон авах гэсэн бодлыг илтгэж байна. Чингис ийнхүү шийдсэн нь эртний Турк, Жужан, Сяньби улсын хаад ноёд Хятадын баян тансагт шунан дурлаж аян дайн хийдэг байсан уламжлалыг дагасан хэрэг байлаа. Хятадад элбэг арвин байх зүйлсийг гар урлалын үйлдвэрлэл бараг огт хөгжөөгүйн улмаас нүүдлийн үйлдвэрлэлийн аргаар нүүдэлчид өөрсдөө үйлдвэрлэх чадваргүй байсан нь ийнхүү тэд олзны хойноос шунан тэмцэх цаад шалтгаан нь болж байв. Бодлогогүй, болчимгүй дайнаас түүнийг тойруулж байдаг өөрийн хувийн сонор сэрэмж, стратегийн холч хараатай байснаараа Чингис нүүдэлчдийн өмнөх хаадаас зарчмын хувьд ялгарч байлаа. Хятадтай дайтахдаа "ар талаа" бэхлэхийн тулд тэрээр 1207 онд "баруун гарын" цэргээ дайлаар мордуулж, урьдаар Ирчис мөрөн хүртэлхи нутагт суух овог аймаг, ардыг эрхэндээ оруулсан. Тэрээр Си-Ся улсыг байлдан дагуулсны дараа л 1214-1215 онд Шар мөрнөөс хойш орших Жин улсын нутгийг эзлэн авсан. Умард Хятадын их бага 862 хотыг монголчууд эзлэн түрэмгийлсэн ажээ. Үүнээс хэдэн жилийн хойно буюу 1219, 1220 онд Шах Мухаммед-Ала ад-Дин /1200-1220 онд төр барьж байсан/-ны лалын шашинт Олон-ястны улсыг Чингис хаан эзлэн авсан.

³ *Die Geheime Geschichte der Mongolen*, hrsg. v. W.Heissig, Köln 1981, S.42.

⁴ Мөн тэнд, 94-р тал.

Ингэснээр Чингис хааны их эзэнт гүрэн барууншаа Арал нуур, Персийн булан, урагшаа Шар мөрөн, зүүн тийш Ляодунгийн хойг хүртэл үргэлжилж байв. Дор хаяж тал хувь орчим нь турк, хятад болон бусад ард иргэдээс бүрдсэн монголын цэрэг Жин улс болон лалын оронд дайтаж, арвин их баялагийг олзолсон. Их хэмжээний эд баялаг эх Монгол нутаг уруу цутган орж байлаа. Олонхи тохиолдолд цэргүүд хотыг тонон дээрэмдсэний хойно үнс нурманд нь хутгаж орхидог байв. Үүнийг учир шалтгааны үүднээс бүрэн тайлбарлаж болно. Чингисийн хувьд хот бол нүүдэлчдийн дайсан болох суурин аж төрөх ёсны арга маягийг өөртөө агуулсан амьдралын нэгэн хэв загвар байлаа. Жишээлбэл хятадуудыг цэргийн хүч хэрэглэх замаар нүүдэлчин ардын нэгэн адил нутгаа орхин явахад хүргэж чадахгүй байсан юм. Тухайн үед монголчууд Хятадын нутгийг бүхлээр "эзэмшилдээ" авах чадваргүй байсан мөн цэрэг хүрэлцэхүйц бус байсан, суурьшмал иргэдийг хэрхэн захирах талаар өчүүхэн ч төдий төсөөлөлгүй байсан учраас хотуудын хүн ам төвлөрсөн хэсгийг эвдлэн бусниулж, тэнд сууж байсан түг түмэн хятадуудыг устгах нь тэднийг бослого тэмцэл зохион байгуулах чадалгүй болгох хамгийн найдвартай арга байлаа. Тариалангийн талбайг бэлчээр болгон хувиргаж байсан баримтыг суурин аж төрөх ёсны хэв маягийн оршин тогтнох үндсийг таслах гэсэн монголчуудын оролдлого хэмээн тайлбарлаж болох юм. Чингис Умард Хятадыг эзэлж чадсан боловч тэр улсыг удирдан жолоодохтой холбогдсон захиргааны асуудлуудыг хэрхэх талаар ямар ч бодлого концепци огт байгаагүй байсныг үүнд мөн дурдалгүй өнгөрч болохгүй. Гэвч түүхэн нөхцөл байдал түүнд тус болсон юм. Чингис Жин улсыг дайрах үед Жин улс хөгжлийнхөө зогсонги үед орсон байлаа. Кидан болон Хятад түшмэд олноороо монголын хааны албанд зүтгэх болсон. Эдгээр түшмэдүүд дотор өөрийн захирч байсан харьяат аймаг мужийг дагуулан монголын талд ирсэн өндөр алба хашдаг түшмэд ч цөөнгүй байв. Тэд удирдан захирах мэдлэг чадвартай байсан төдийгүй дайны олз омог зөвхөн нэг удаагийнх байдаг бол тухайн улсыг захирч чадваас тэндээс удаан хугацааны туршид ашиг тусыг олох болно гэдгийг Чингист ойлгуулах хэрэгтэйг тэд ухаарч байлаа. Ашигтай чухал зүйлийг түргэн таньж, оновчтой ашиглах оюуны их чадвар Чингист байв. Тэрээр түшмэдүүдээ ихээхэн эрх мэдэл олгосон. Хятадын төрийн удирдлагын уламжлалыг эрх мэдлийг гартаа атгах гэсэн монголын эрмэлзэлтэй бүтээлчээр хослуулах замаар Умард Хятадад монголчууд засаг захиргааг өөртөө шилжүүлж чадсан юм. Дайн байлдааныг хийх үед монгол цэргийн жанжин нарын улс төрийн нөлөө давамгайлж байсан бол удаахь хоёрдугаар шатанд кидан, хятадын түшмэдийн нөлөө нэмэгдсэн байлаа. Гэхдээ гэнэт ийнхүү өөрчлөгдсөн гэж бид ойлгож болохгүй юм. Энэхүү синтез нь он удаан хугацааны туршид явагдсан юм.

Шах Мухаммед Ала ад-Дин /1200-1220 онд төр барьж байсан/-ны лалын шашинт Олон - ястны улсыг эзэлсний хойно Чингис цоо шинэ нэгэн төвөгтэй асуудалтай тулгарсан. Умард Хятадын хүн ам угсаатны хувьд харьцангуй нэг төрлийн байсан бол Шах Мухаммедийн харьяат ардууд нь хотноо суурин суух иранчууд болон турк угсааны нүүдэлчдээс бүрдэж байв. Хүн амын энэхүү хоёр хэсгийн оршин суух газраар улсын нутаг дэвсгэр хөндлөн чигт хоёр хуваагдаж байв. Умард хэсгийн тал нутагт турк угсааны нүүдэлчид амьдарч, өмнө зүгийн хотуудад иранчууд суурьшсан байлаа. Угсаатны хувьд нэгэн төрлийн бус хүн амыг их бага ямар нэгэн хэмжээгээр хооронд нь холбон нэгтгэгч нь лалын шашин

байсан бөгөөд лалын шашин монголчуудыг "Сүсэггүй этгээд" хэмээн үзэж, дайсныхаа тоонд оруулж байв. Турк угсааныхан монголчуудад ихэвчлэн сайн дураараа нэгдэн орж байхад хотын суурьшмал иргэд монголчуудын довтолгоог аль ч үед хүчтэй эсэргүүцэж байсан. Монголчуудыг өөрсдийн шашины эвлэршгүй дайсан хэмээн эрс эсэргүүцэн тэмцэгч нартай Чингис ийнхүү анх удаа нүүр тулан учирсан ажээ. Монголчууд ч мөн тэдэнд мөн тохирох хариуг өгч, ихэнх хотыг нь үнсэн товрог болгож, ард иргэдийг нь хүйс тэмтрэх буюу дайчлан ажиллуулахаар нутаг заан явуулж эсвэл цэргийн албанд татаж байжээ.

Лалын шашинт нутагт хийсэн монголчуудын довтолгоо сөрөг үр дүнг авчирсан нь илхэн байлаа. Хотуудыг эзлэн, хүн ардыг нь алж талснаар улсын эдийн засгийн амьдралд өргөн цар хүрээтэй үр дагаврыг авчирсан юм. Гар урлалын үйлдвэрлэл зогсонги байдалд орж, Бухар, Самарканд зэрэг уламжлалт худалдаа арилжааны газрууд ач холбогдлоо алдсан. Хэрэглэгч үгүй газар зах зээл оршин тогтнох нь утга учиргүй болдог. Алс холын орнуудтай хийх арилжаа наймаа зогссоны улмаас эртний худалдааны замаар тээвэр ч хийгдэхээ больсон байлаа. Ийм нөхцөл байдалд худалдааны замын аюулгүй байдлыг хангана гэдэг боломжгүй зүйл байв. Засаг захиргаа үгүй болж, *law and order* нуран унасан байлаа. Аливааг дур зоргоор шийдэж байсан бөгөөд зарим газар монголын ноёрхлын эсрэг анхны бослого тэмцэл гарч эхэлсэн. Монгол хааны яаралтай элч энэ нутгаар эсэн мэнд явж өнгөрөхийн тулд 300-400 цэрэг дагалдуулж явахаас аргагүй байсан тухай Рашид ад-Дин бичсэн байдаг.⁵ Энд бослого тэмцлийг өрнөхөөс өмнө бага дээр нь дарж авахын тулд монгол цэргийн эргүүлийн шуурхай анги байнга хөндлөн гулд явж цагдаж байв. Энэ үед *Pax Mongolica* огт байсангүй. Эзлэгдсэн орныг захирахын ач холбогдлыг Чингист ухуулах хэрэгтэй ч лалын түшмэд хятадын нэгэн адил ойлгосон. Ялавачи, Махсут хэмээх эцэг хүү хоёр лал мөргөлт хотуудын утга учир, ач холбогдлыг Чингист тайлбарлан хэлсэн нь Чингис хотуудад захирагч нарыг томилон явуулахад хүргэсэн тухай *Монголчуудын Нууц Товчоонд* бичиглэн үлдээжээ.⁶ Эзэнт гүрэнд засаг захиргааны үндэс суурь тавигдсан байлаа.

Чингис эзэнт гүрнийхээ газар нутгийг бүхэлд нь ганцаараа өмчлөн эзэмшигч нь байв. 1229 онд Өгөдэй Монголын их хааны халааг авч, Монголын хаанд өргөмжлөгдсөн. Мөн Чингис хааны хөвгүүд эзэнт их гүрний томоохон хэсгүүдийн захирагчаар тохоон томилогдсон. Тэд хотын соёлыг хадгалан үлдээх, сэргээх, лалын нутагт эдийн засгийн амьдралыг сэргээн хөгжүүлэхийг сонирхох явдал илтэд өсч байлаа. Тэдний удирдлаган доорхи газар нутгийн засаг захиргаа нь 1-т монголын эрх мэдлийг хадгалах гэсэн үндсэн асуудлыг шийдэхийн хамт 2-т эдийн засаг хөгжин цэцэглэх урьдач нөхцлийг хангаж, удаан хугацааны туршид ашиг тусаа өгнө гэдгийг тэд хэдийнээ ойлгож байв. Иймээс тэд лалын зөвлөх түшмэдээр хүрээлүүлсний зэрэгцээ тэдэнд засаг захиргааны асуудалд бүрэн дүүрэн эрх олгосон байв.

Өгөдэй эцгийнхээ байлдан дагууллыг үргэлжлүүлж, 1234 онд тэрээр Умард Хятадыг бүхлээр нь өөрийн захиргаанд оруулсан. Жин

⁵ Рашид ад-Дин, *Сборник летописей*. Том II, Книга вторая, Москва, Ленинград 1952.

⁶ *Die Geheime Geschichte der Mongolen*, hrsg. v. W.Heissig, Köln 1981, S.159.

улсын ноёрхол эцэс болов. 1235 оны Их Хурилдайгаар өрнө зүг томоохон аян дайныг дахин хийх шийдвэрийг гаргасан. Бат хаанд /1256 онд нас барсан/ ерөнхий жанжны тушаах эрхийг итгэмжлэн олгосон. Бат хаан их цэргээ авч Дорнод Европын гүнд нэвтрэн орсон. Түүний цэрэг эрс Хятад болон лалын нутагт хэрэглэж дадсан тэр л аргаараа хандаж хот тосгодыг эвдэн сүйтгэж, хүн ардыг нь алж талж байлаа. Өгөдэй хаан таалал төгссөний улмаас 1241 онд их цэрэг гэдрэгээ буцсанаар олон газруудад хүмүүс дахин шинээр суурьшихаас аргагүй болсон. Тухайлбал өнөөгийн зүүн Словакийн нутагт олон тооны закончууд ийнхүү нутагшиж эхэлсэн юм.

Өгөдэй хааны үед төв засаг захиргааг байгуулж, эзэлсэн газруудад монголын ноёрхлыг тогтворжуулж эхэлсэн. Орон нутагт засаг захиргааны болон алба татварын тогтолцоог бүрдүүлэх ажлыг хянах үүрэг бүхий өөрийн төлөөний хүнийг эзэнт их гүрний янз бүрийн хэсгүүдэд Өгөдэй томилон явуулсан. Дотоод байдал тогтворжсон. Их эзэнт улсын нийслэл Хархориныг Зүүнгар, Казахстангаар дайруулан Доод Волгын сав газартай холбосон өртөө замыг байгуулсан нь нэгэн чухал ажил байлаа. Өртөө замыг богино хугацааны дотор өртгөтгөн барьсан бөгөөд өртөөний буудлуудыг барьж, түүнд хоол хүнс, унаа морьдыг бэлтгэсэн байна. Монголын цэргүүд энэхүү өртөө замыг сахин хамгаалж байв.

Монголын өртөө байгууламжаар 1253-1254 оны үед зорчсон Францисканы лам Вильгелм фон Рубрук бидэнд энэ өртөөгөөр тээвэр хийх хүч чадавхийн талаар нэгэн тодорхой төсөөллийг бидэнд өгч байна. Хар тэнгис орчмын Судакаас Сарай хүртэлхи ямар нэгэн өртөө холбоогүй 1000-аад км замыг туулахад түүнд хоёр сар орчим хугацаа шаардлагатай байсан бол Сарайгаас Хархорин хүртэлхи 3900-аад км газрыг монголын өртөөгөөр дамжин бараг 3,5 сарын дотор туулан ирсэн байна.⁷

Алтан ордны нийслэл бөгөөд Бат хааны ордон орших Сарай хот нь баруун захын өртөөний нэг болохын хувьд онцгой үүрэг гүйцэтгэж байсан юм. 1227 онд Зүчийг нас барсны дараа түүний эзэмшил газрыг Бат хаан авсан. Ийнхүү Алтан Ордны улс баруун зүгт Дунай мөрний доод адаг, өмнө зүгт Хар тэнгис, зүүн зүгт Ирчис мөрөн, хойд зүгт Монголд алба барьдаг Оросын нутагтай тус тус хиллэж байв. Үүнд Хар тэнгисийн бүс нутаг онцгой ач холбогдолтой байлаа. Ромын эзэнт гүрний эртний нийслэл Византи хэмээгдэж байсан Константинополь хот Хар тэнгисийн эрэг дээр оршиж байлаа. Киевийг дайран Зүүн Европт, Каспийн тэнгисийг дайран Хятад, Трапецунт, Тебрисыг дайран Энэтхэг, Хятадад очих худалдааны чухал замууд эрт үед Константинополь, Хар тэнгисийг дайран гардаг байлаа. Ялангуяа хоорондоо өрсөлдсөөр ирсэн далайн бүгд найрамдах улсууд болох Венец, Генуя хоёр Хар тэнгисийн эрэг дээр орших хотуудаар дамжуулан XIII зууны эхэн үеэс хойш харь холын улс орнуудтай худалдаа наймаа хийж байв.⁸ Католикийн сүмийн

⁷ cf. Wilhelm von Rubruk - Reise zu den Mongolen 1253-1255, übersetzt und erläutert von F. Risch, = Veröffentlichungen des Forschungsinstitutes für Vergleichende Religionsgeschichte an der Universität Leipzig, II. Reihe Heft 13, Leipzig 1934.

⁸ cf. Die Goldene Horde - Die Mongolen in Russland 1223-1502, Leipzig 1943.

тэргүүн Пап лам лалын шашинтангууд болон ялангуяа Египетийн мамлюк нартай худалдаа хийхийг хориглосон учраас Венец болон Генуягийн худалдааны пүүсүүдийн хувьд загалмайн бодлогын үүднээс Хятадтай хийх худалдаа асар их ач холбогдолтой байсан юм. Пап лам болон Европын хаад монголчуудыг лалын эсрэг бидний холбоотон гэж тухайн үед итгэж байсан тул Пап лам монголчуудтай худалдаа хийхийг хориглоогүй юм. Монголчуудын ноёрхлын бүсээр дамжиж алс холын орнуудтай худалдаа арилжааг явуулахад таатай сайхан бололцоог монголчууд олгох болсныг Венец, Генуягийн худалдаачид даруй XIII зууны хоёрдугаар хагасаас олж мэдсэн ажээ. Газарзүйн алслагдмал байрлалын улмаас Хятад хүрэх зам аюулгүй байх, жингийн цуваа аюулд өртөхгүй, баталгаатай байх нь асар их ач холбогдолтой байв. Энэ их эзэнт гүрэнд монгол, перс хэл харилцааны гол хэрэглүүр болж байсан нь Монголын эзэнт их гүрний худалдааны замд нэгэн давуу талыг олгож байлаа.

Худалдааны пүүсүүд Алтан Ордны улс болон Ил Хаадын улстай холбоо харилцааг тогтоосон байв. Алс холын улс орнуудтай эрт үед хийж байсан худалдаа арилжааны талаар өнөөг хүртэл яригддаг зүйлийн тухайд хэлэхэд монголын их эзэнт гүрэн худалдааны замын аюулгүй байдлыг хангаж байсны үр шим, ашиг тусыг нь хүртэж байсан нь зөвхөн европчууд төдий биш мөн Төв Азийн лалын худалдаачид, еврейчүүд, хятадууд худалдааны замыг ашиглаж байжээ. Рубрук аяллынхаа явцад германы ба еврейчүүдийн сууринтай таарч байсан байна. Тебрис, Москва, Новгородод хэдийнээ хятад хороолол үүссэн байв.⁹ *Pax Mongolica*-гийн эрин үе эхэлсэн байлаа.

Эцэст нь товч дүгнэн хэлэхэд *Pax Mongolica* бол Монголын эрх баригчдын өөрсдийнх нь оюун ухаанаас урган гарсан зүйл байсан бөгөөд тэд аян дайн хийж олз омог олохоос илүүтэйгээр Эзэнт их гүрнээ засан захирах явдалд голлон анхаарах болсон нь хятад болон лалын зөвлөх түшмэд нарынх нөлөө нэг талаар байсан юм. Уг үйл явцыг энэхүү илтгэлдээ тодруулахыг хүссэн юм. Гэвч Өгөдэй хаанаас хойшхи үед *Pax Mongolica* хэрхэн, ямар байдалтай байсан талаар цаашид судлах шаардлагатай байна.

⁹ J Gernet, *Die chinesische Welt*, Frankfurt a. Main 1979, S.320.